

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Баян-агт сумын Ерөнхий боловсролын сургууль 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2026/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Булган аймаг 2026 он	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn
	“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com
	“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24. № 220.
танай _____ ны № _____ т

Баян-АГТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 483 хүүхдэд ерөнхий боловсрол олгох, дотуур байранд 110 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулан гүйцэтгэлээр санхүүжсэн. Тайлант онд Булган аймгийн ЗДТГ-аас 15,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас 12,600.0 мянган төгрөгийн бараа материал, орон нутгийн иргэдийн хөрөнгө оруулалтаас 26,050.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 3,855.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор "Цалин хөлс шинэчлэн батлах тухай" төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна.

Боловсролын ерөнхий газрын 2025 оны 01 сарын 23-ны 1/383 албан тоотоор 2024-2025 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор 2025 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийн ашиглалтын үр дүнг сайжруулах, зөв зохистой удирдах, өр, авлага үүсгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллахыг

6326050264

чиглэл болгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 3 зорилтын хүрээнд 28 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллан 82.9 хувьтай дүгнүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>322,844,174.57</u>	<u>255,837,982.30</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	155,769,275.89	123,609,416.66
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	155,769,275.89	123,609,416.66
3121	Төгрөг	155,769,275.89	123,609,416.66
31211	Төрийн сангийн харилцах	155,769,275.89	123,609,416.66
33	АВЛАГА	5,049,224.54	1,398,023.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,049,224.54	1,398,023.00
35	БАРАА МАТЕРИАЛ	162,025,674.14	130,830,542.64
351	Түүхий эд материал	14,849,937.10	17,572,282.00
35110	Тусгай зориулалттай материал	14,635,937.10	17,572,282.00
354	Хангамжийн материал	147,175,737.04	113,258,260.64
35410	Бичиг хэргийн материал	21,491,550.00	5,938,000.00
35420	Аж ахуйн материал	104,566,432.64	92,641,585.64
35440	Түлш, шатах тослох материал	-	900,000.00
35470	Бусад хангамжийн материал	10,886,281.40	13,778,675.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,795,984,241.03</u>	<u>1,741,273,501.41</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,795,984,241.03	1,741,273,501.41
392	Биет хөрөнгө	1,756,116,741.03	1,701,743,501.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,543,011,910.00	1,606,131,910.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(255,125,275.47)	(303,572,544.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	48,900,000.00	48,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(8,150,000.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	483,227,820.00	525,571,739.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(164,465,432.31)	(256,191,829.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	158,549,936.11	162,829,936.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	(86,116,207.27)	(101,909,698.99)
39217	Ном	28,133,989.97	28,133,989.97
393	Биет бус хөрөнгө	39,867,500.00	39,530,000.00
39301	Програм хангамж	1,750,000.00	1,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,412,500.00)	(1,750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,530,000.00	39,530,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,118,828,415.60</u>	<u>1,997,111,483.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,066,919.00</u>	<u>20,509,739.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,066,919.00	20,509,739.00
413	Өглөг	10,066,919.00	20,509,739.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,114,510.00	439,200.00
4136	Бусад өглөг	8,952,409.00	20,070,539.00
41361	Байгууллагад төлөх өглөг	8,952,409.00	20,070,539.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,108,761,496.60</u>	<u>1,976,601,744.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,108,761,496.60	1,976,601,744.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	796,350,796.72	796,350,796.72
512	Хуримтлагдсан үр дүн	172,976,051.04	40,816,299.15
51210	Өмнөх үеийн үр дүн	172,976,051.04	172,976,051.04
51220	Тайлант үеийн үр дүн	-	(132,159,751.89)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,139,434,648.84	1,139,434,648.84

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,118,828,415.60	1,997,111,483.71
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,513,723,800.00	2,689,081,690.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,513,723,800.00	2,689,081,690.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,151,034,300.00	2,349,438,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,151,034,300.00	2,349,438,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,499,600.00	1,048,390.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,499,600.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,048,390.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	345,189,900.00	338,595,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	345,189,900.00	338,595,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,407,310,133.67	2,923,233,795.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,407,310,133.67	2,923,233,795.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,329,315,773.02	2,838,715,855.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,560,696,873.26	1,845,654,267.54
210101	Үндсэн цалин	1,007,652,720.96	1,078,478,801.16
210102	Нэмэгдэл	480,365,181.57	642,358,267.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	39,731,600.00
210104	Урамшуулал	72,678,970.73	85,085,599.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,882,591.84	228,639,526.19
210201	Тэтгэврийн даатгал	117,780,898.47	158,298,159.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,276,551.64	18,203,783.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,036,672.56	9,183,864.26
210204	Ажилгүйдлийн даатгал	7,157,673.89	8,899,507.26
210205	Эрүүл мэндийн даатгал	28,630,795.28	34,054,212.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	292,622,157.95	315,505,168.37
210301	Гэрэл, цахилгаан	11,500,000.00	19,026,239.25
210302	Түлш, халаалт	276,662,657.95	287,769,516.32
210303	Цэвэр, бохир ус	4,459,500.00	8,709,412.80
2105	Нормативт зардал	118,820,960.80	144,479,970.50
210502	Хоол, хүнс	118,820,960.80	144,479,970.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,138,400.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	8,138,400.00	11,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,256,048.03	14,058,297.04
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,256,048.03	14,058,297.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,898,741.14	279,378,625.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,451,885.00	95,067,577.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,740,100.00	16,254,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,706,756.14	168,056,748.62

Булган аймгийн Баян-агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,994,360.65	84,517,940.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,354,618.60	74,400,008.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,354,618.60	74,400,008.90
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,639,742.05	10,117,931.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,639,742.05	10,117,931.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	106,413,666.33	(234,152,105.79)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	106,413,666.33	(234,152,105.79)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,513,723,800.00	2,689,081,690.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,513,723,800.00	2,689,081,690.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,151,034,300.00	2,349,438,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,151,034,300.00	2,349,438,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,499,600.00	1,048,390.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,499,600.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,048,390.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	345,189,900.00	338,595,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	345,189,900.00	338,595,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,353,706,772.48	2,697,153,849.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,353,706,772.48	2,697,153,849.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,276,174,826.43	2,606,329,507.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,556,814,027.10	1,847,032,290.54
210101	Үндсэн цалин	991,672,536.63	1,079,856,824.16
210102	Нэмэгдэл	492,493,057.52	642,358,267.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	39,731,600.00
210104	Урамшуулал	72,648,432.95	85,085,599.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,690,755.35	223,590,301.65
210201	Тэтгэврийн даатгал	120,849,418.91	153,248,934.46
210202	Тэтгэмжийн даатгал	15,250,015.42	18,203,783.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,764,392.81	9,183,864.26
210204	Ажилгүйдлийн даатгал	7,366,321.65	8,899,507.26
210205	Эрүүл мэндийн даатгал	29,460,606.56	34,054,212.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,550,157.95	317,477,168.37
210301	Гэрэл, цахилгаан	11,500,000.00	19,026,239.25
210302	Түлш, халаалт	276,662,657.95	288,669,516.32
210303	Цэвэр, бохир ус	3,387,500.00	9,781,412.80
2105	Нормативт зардал	107,474,053.00	130,876,900.00
210502	Хоол, хүнс	107,474,053.00	130,876,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,000,000.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	33,000,000.00	11,000,000.00

Булган аймгийн Баян-агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,757,848.03	18,907,097.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,916,900.00	1,756,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,840,948.03	17,150,397.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,887,985.00	57,445,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,411,185.00	46,826,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,476,800.00	10,619,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,531,946.05	90,824,341.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,892,204.00	80,706,410.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,892,204.00	80,706,410.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,639,742.05	10,117,931.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,639,742.05	10,117,931.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	160,017,027.52	(8,072,159.23)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	105,358,106.00	27,105,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,358,106.00	27,105,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	105,358,106.00	27,105,000.00
222001	Тоног төхөөрөмж	99,163,006.00	17,540,000.00
223001	Бусад хөрөнгө	6,195,100.00	9,565,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(105,358,106.00)	(27,105,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	54,658,921.52	(35,177,159.23)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		155,769,275.89
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	155,769,275.89	123,609,416.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	(109,367,126.39)	1,826,418,319.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	(109,367,126.39)	1,826,418,319.17
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	282,343,177.43	282,343,177.43
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	172,976,051.04	2,108,761,496.60
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	172,976,051.04	2,108,761,496.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	172,976,051.04	2,108,761,496.60

Булган аймгийн Баян-агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(132,159,751.89)	(132,159,751.89)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	40,816,299.15	1,976,601,744.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/ Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,920,722,700.00	2,714,140,917.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,920,722,700.00	2,687,035,917.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,834,331,400.00	2,606,329,507.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,976,458,300.00	1,847,032,290.54
210101	Үндсэн цалин	1,215,829,600.00	1,079,856,824.16
210102	Нэмэгдэл	725,778,200.00	642,358,267.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	39,731,600.00
210104	Урамшуулал	34,850,500.00	85,085,599.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,057,400.00	223,590,301.65
210201	Тэтгэврийн даатгал	167,999,000.00	153,248,934.46
210202	Тэтгэмжийн даатгал	19,764,600.00	18,203,783.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,882,300.00	9,183,864.26
210204	Ажилгүйдлийн даатгал	9,882,300.00	8,899,507.26
210205	Эрүүл мэндийн даатгал	39,529,200.00	34,054,212.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	364,595,100.00	317,477,168.37
210301	Гэрэл, цахилгаан	18,000,000.00	19,026,239.25
210302	Түлш, халаалт	336,595,100.00	288,669,516.32
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	9,781,412.80
2105	Нормативт зардал	130,876,900.00	130,876,900.00
210502	Хоол, хүнс	130,876,900.00	130,876,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	11,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,579,800.00	18,907,097.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,396,900.00	1,756,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,182,900.00	17,150,397.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,763,900.00	57,445,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,144,800.00	46,826,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,619,100.00	10,619,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,391,300.00	80,706,410.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,391,300.00	80,706,410.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,391,300.00	80,706,410.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	27,105,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	27,105,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	17,540,000.00

223001	Бусад хөрөнгө	-	9,565,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,688,033,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	2,349,438,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	2,349,438,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	338,595,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	338,595,100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		155,769,275.89
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		123,609,416.66

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,296.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,756.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,435.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 12,920.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 184.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Залруулсан алдаа:

- Тодруулгын авлага Санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдэлтэй 3.756.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана". Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу тайлагнагдаагүй байна.

5.1 Төлбөрийн акт

- *Илрүүлэлт:* Хүнсний материалын норм норматив, зарцуулалт, үлдэгдлийг шалгахад анхан шатны баримт шаардлага хангахгүй хүүхдийн ирц өдөрлөгийн ирцтэй тохирохгүй зэрэг зөрчилтэй, хүнсний материалд биет тооллогыг хийхэд 951.0 мянган төгрөгийн хүнсний дутагдалтай байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 5 дугаар зүйлийн 5.1.3. "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- *Илрүүлэлт:* Багш нарын баярын арга хэмжээний тэмцээн уралдаанд оролцсон Дуу хөгжмийн багш Х.Гантулгад нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 484.0 мянган төгрөгийн урамшууллыг буруу эрх зүйн үндэслэлээр үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дугаар зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" Засгийн 2019 оны газрын 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2. "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.2 Албан шаардлага

- **Илрүүлэлт:** Тус сургуулийн захирал хөдөлмөр аюулгүй байдлын ажилтны албан тушаалыг 1 сар хавсран гүйцэтгэж 654.8 мянган төгрөгийн цалин авсан нь Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2."Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна". 27 дугаар зүйлийн 27.4."Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна". гэсэн заалт зөрчигдсөн байна.
- **Илрүүлэлт:** Тайлант онд 5 багшид 3 710.0 мянган төгрөгийн / шилдэг ажилтны шагнал/ нэг удаагийн шагнал урамшууллыг олгохдоо цалингийн зардлаас цалингаар тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.6.3-д "Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх", Сангийн сайдын 2023 оны 221 тушаалаар батлагдсан " ангилал шинэчлэн батлах тухай журам"-ын 2-р хавсралтын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын Урамшуулалд хамаарахгүй зүйлс нь НДШ төлөхгүй нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшуулал " гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
- **Илрүүлэлт:** Моби нет төхөөрөмжийг зээлээр худалдан авах гэрээг хийн худалдан авсан тушаал шийдвэр байхгүй, цахим дэлгүүрт байхгүй компаниас худалдан авалт хийж тухайн жилд төлөх төлбөрийг төлж 8 556.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2 ".Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна".Төсвийн тухай хууль 6.6.2".төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх". заалтууд зөрчигдсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлагналын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлангийн хугацаанд тус сургуулийн нягтлан бодогч, нярав солигдсон байна. Санхүүгийн ажилтан солигдоход ажил хүлээлцэх тушаал гарсан боловч тооллого тооцоо хийж хөрөнгө өр төлбөрийг хүлээлгэж өгөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12 дугаар зүйлийн 12.2.2 ".эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" хөрөнгө өр төлбөрийн тооллогыг заавал хийнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг судлах.

2. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд 19673 м.кв хэмжээтэй газар эзэмших эрх тус байгууллагын эзэмшилд байх боловч Санхүүгийн тайланд Биет бус хөрөнгийн дансанд 19765м.кв хэмжээтэй бүртгэгдсэн байгаа нь 92 м.кв -аар 184.0 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэгдсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1" үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх", Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 10-р тогтоолын 7 дахь заалт" зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 112.886.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй 175 нэр төрлийн 610 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах",ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэсэн заалт зөрчигдөж байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан	1	3,756.2			1	3,756.2	1	3,756.2				
Дүн	1	3,756.2			1	3,756.2	1	3,756.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүнсний материалын дутагдал	1	951.0	1	951.0								
Үр дүнгийн урамшуулал илүү авсан	1	1,484.0	1	1,484.0								
Бүтэц орон тоонд заагдаагүй хавсран гүйцэтгүүлсэн	1	654.8			1	654.8						

Булган аймгийн Баян-агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Нэг удаагийн шагнал урамшуулал олгосон	1	3,710.0			1	3,710.0					
Өглөг үүсгэсэн	1	8,556.0			1	8,556.0					
Нярав, нягтлан ажил хүлээлцээгүй	1						1	0			
Газрын хэмжээ зөрсөн	1	184.0					1	184.0			
Тэг үлдэгдэлтэй хөрөнгө	1	0					1	0			
Дүн	9	15,539.8	2	2,435.0	3	12,920.8	3	184.0			